

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2026 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2026 оны 06-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobicashmere.com Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Дэлгүүр: Дотоод Улаанбаатар хот 3 Онлайн: gobi.mn Гадаад Салбар дэлгүүр 2 Франчайз дэлгүүр 5 Онлайн: gobicashmere.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж (MSE:GOV)
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Амарсайхан /Гүйцэтгэх захирал/
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1.	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН <i>(мян.төг)</i>		
		2025.12.31	2026.06.30
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,804,394	2,614,287
	Дансны ба бусад авлага	3,944,115	7,241,330
	Урьдчилгаа төлбөр	5,490,244	13,978,125
	Бараа материал	124,806,536	216,035,273
		137,045,289	239,869,015
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	134,499,342	136,317,092
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	3,068,800	2,260,670
	Хойшлогдсон татварын хөрөнгө	6,541,951	4,994,908
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	21,093,186	23,545,244
		165,203,279	167,117,914
	Нийт хөрөнгө	302,248,568	406,986,929
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	10,930,011	5,626,242
	Гэрээний өр төлбөр	2,044,536	2,531,175
	Богино хугацаат түрээсийн өглөг	1,404,476	985,878
	Орлогын албан татварын өглөг	1,712,320	1,125,091
	Богино хугацаат зээл	171,986,397	234,918,082
		188,077,740	245,186,468
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,494,543	1,133,609
	Урт хугацаат зээл	115,683,447	171,055,667
	Бусад урт хугацаат өглөг	1,355,833	-
	Хойшлогдсон татварын өглөг	17,793,063	17,479,353
		136,326,886	189,668,629
	Нийт өр төлбөр	324,404,626	434,855,097
	Эзэмшигчдийн өмч		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нэмэгдэл	42,416,645	42,416,645
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(35,936,297)	(34,465,295)
	Хуримтлагдсан алдагдал	(29,416,519)	(36,599,631)
	Нийт эздийн өмч	(22,156,058)	(27,868,168)
	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	302,248,568	406,986,929

1.2.	Орлогын тайлан		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН (мян.төг)		
		2025.12.31	2026.06.30
	Борлуулалтын орлого	246,187,537	84,147,667
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(127,901,880)	(43,245,607)
	Нийт ашиг	118,285,657	40,902,060
	Бусад орлого	22,051,504	2,201,348
	Борлуулалт ба маркетингийн зардал	(57,344,113)	(23,018,487)
	Ерөнхий ба удирдлагын зардал	(24,507,306)	(11,047,668)
	Бусад зардал	-	918,171
	Санхүүгийн орлого	1,323,690	1,190
	Санхүүгийн зардал	(54,912,109)	(14,691,307)
	Татварын өмнөх ашиг (алдагдал)	4,897,323	(4,734,693)
	Орлогын татварын зардал	(4,693,998)	(2,448,418)
	Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)	203,325	(7,183,111)
	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
	Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(23,816,508)	1,471,002
	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)	(23,816,508)	1,471,002
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	(23,613,183)	(5,712,109)
	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал) - төгрөгөөр	0.26	(9.21)

1.3.	Өмчийн өөрчлөлтийн тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (мян.төг)					
		Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
	2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	203,325	203,325
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(23,816,508)	-	(23,816,508)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(23,816,508)	203,325	(23,613,183)
	Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(1,360,741)	-	1,360,741	-
	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	42,416,645	(35,936,296)	(29,416,519)	(22,156,058)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(7,183,112)	(7,183,112)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,471,002	-	1,471,002
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	1,471,002	(7,183,112)	(5,712,110)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2026 оны 06 сарын 30-ны үлдэгдэл	780,113	42,416,645	(34,465,295)	(36,599,631)	(27,868,168)
1.4.	Мөнгөн гүйлгээний тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (мян.төг)					
		2025.12.31		2026.06.30		
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	35,496,370		(103,535,267)		
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(10,723,122)		(9,574,096)		
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,593,601)		112,929,644		
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,179,647		(179,719)		
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү	(23,816,508)		1,471,002		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	115,209		(1,481,390)		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,326,046		2,804,394		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,804,394		2,614,287		

2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт																																											
	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь 2026 оны 07-р сарын 22-ны өдөр Говь ХК-ийн 2026 оны хагас жилийн санхүүгийн тайлантай цахим хэлбэрээр танилцаж, тус тайлан нь холбогдох хууль, дүрэм журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болохыг хүлээн зөвшөөрч, олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.																																											
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																																											
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/																																											
	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th><th>Хэмжих нэгж</th><th>2025.06.30</th><th>2026.06.30</th><th>Өөрчлөлт</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Борлуулалтын орлого</td><td>сая.төг</td><td>76,911</td><td>84,148</td><td>9.4%</td></tr> <tr> <td>Нийт ашиг</td><td>сая.төг</td><td>35,503</td><td>40,902</td><td>15.2%</td></tr> <tr> <td>Цэвэр ашиг (алдагдал)</td><td>сая.төг</td><td>(19,171)</td><td>(7,183)</td><td>162.5%</td></tr> <tr> <td>Нийт ашгийн хувь</td><td>хувь</td><td>46.2%</td><td>48.6%</td><td>5.3%</td></tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td><td>хувь</td><td>-24.9%</td><td>-8.5%</td><td>165.8%</td></tr> <tr> <td>Хөрөнгийн өгөөж</td><td>хувь</td><td>-5.4%</td><td>-1.8%</td><td>167.2%</td></tr> <tr> <td>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</td><td>төг</td><td>(24.58)</td><td>(9.21)</td><td>162.5%</td></tr> </tbody> </table> Өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 9.4%-аар буюу 7.2 тэрбум төгрөгөөр өссөн. Үүнд дотоодын борлуулалт 4.9 тэрбум төгрөгөөр, экспортын (Глобал) борлуулалт 2.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Нийт ашгийн маржин 46.2%-аас 48.6% болж 2.4 нэгж хувиар сайжирсан нь бүтээгдэхүүний өртгийн удирдлага болон үнийн бодлогын үр дүнтэй холбоотой юм. Түүнчлэн үйл ажиллагааны зардал 2.5 тэрбум төгрөгөөр, валютын ханшийн хэлбэлзлээс үүссэн алдагдал 3.6 тэрбум төгрөгөөр, санхүүжилтийн зардал 1.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь ашигт ажиллагааг дэмжив. Үүний үр дүнд цэвэр алдагдал өмнөх оны мөн үеэс 12.0 тэрбум төгрөгөөр буурч, цэвэр ашгийн маржин -24.9%-аас -8.5% болж сайжирсан. Мөн хөрөнгийн өгөөж -5.4%-аас -1.8% болж, нэгж хувьцаанд ногдох алдагдал 24.58 төгрөгөөс 9.21 төгрөг хүртэл буурсан нь компанийн санхүүгийн үзүүлэлтүүд мэдэгдэхүйц сайжирсныг илэрхийлж байна.				Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025.06.30	2026.06.30	Өөрчлөлт	Борлуулалтын орлого	сая.төг	76,911	84,148	9.4%	Нийт ашиг	сая.төг	35,503	40,902	15.2%	Цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	(19,171)	(7,183)	162.5%	Нийт ашгийн хувь	хувь	46.2%	48.6%	5.3%	Цэвэр ашгийн хувь	хувь	-24.9%	-8.5%	165.8%	Хөрөнгийн өгөөж	хувь	-5.4%	-1.8%	167.2%	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	төг	(24.58)	(9.21)	162.5%
Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025.06.30	2026.06.30	Өөрчлөлт																																								
Борлуулалтын орлого	сая.төг	76,911	84,148	9.4%																																								
Нийт ашиг	сая.төг	35,503	40,902	15.2%																																								
Цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	(19,171)	(7,183)	162.5%																																								
Нийт ашгийн хувь	хувь	46.2%	48.6%	5.3%																																								
Цэвэр ашгийн хувь	хувь	-24.9%	-8.5%	165.8%																																								
Хөрөнгийн өгөөж	хувь	-5.4%	-1.8%	167.2%																																								
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	төг	(24.58)	(9.21)	162.5%																																								
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																																											
	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th><th>Хэмжих нэгж</th><th>2025.12.31</th><th>2026.06.30</th><th>Өөрчлөлт</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td><td>дахин</td><td>0.73x</td><td>1.40x</td><td>92.6%</td></tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td><td>дахин</td><td>0.04x</td><td>0.10x</td><td>120.1%</td></tr> <tr> <td>Өр төлбөр / Өөрийн хөрөнгө</td><td>дахин</td><td>(8.49x)</td><td>(6.13x)</td><td>127.8%</td></tr> <tr> <td>Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө</td><td>хувь</td><td>107.3%</td><td>106.8%</td><td>-0.5%</td></tr> <tr> <td>Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</td><td>сая.төг</td><td>2,804</td><td>2,614</td><td>-6.8%</td></tr> <tr> <td>Эргэлтийн хөрөнгө</td><td>сая.төг</td><td>137,045</td><td>239,869</td><td>75.0%</td></tr> </tbody> </table> Тайлант хугацаанд компанийн хөрвөх чадварын үзүүлэлтүүд мэдэгдэхүйц сайжирсан.				Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025.12.31	2026.06.30	Өөрчлөлт	Эргэлтийн харьцаа	дахин	0.73x	1.40x	92.6%	Түргэн хөрвөх чадварын харьцаа	дахин	0.04x	0.10x	120.1%	Өр төлбөр / Өөрийн хөрөнгө	дахин	(8.49x)	(6.13x)	127.8%	Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө	хувь	107.3%	106.8%	-0.5%	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	сая.төг	2,804	2,614	-6.8%	Эргэлтийн хөрөнгө	сая.төг	137,045	239,869	75.0%					
Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025.12.31	2026.06.30	Өөрчлөлт																																								
Эргэлтийн харьцаа	дахин	0.73x	1.40x	92.6%																																								
Түргэн хөрвөх чадварын харьцаа	дахин	0.04x	0.10x	120.1%																																								
Өр төлбөр / Өөрийн хөрөнгө	дахин	(8.49x)	(6.13x)	127.8%																																								
Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө	хувь	107.3%	106.8%	-0.5%																																								
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	сая.төг	2,804	2,614	-6.8%																																								
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	137,045	239,869	75.0%																																								

	Эргэлтийн харьцаа 0.73 дахинаас 1.40 дахин болж 92.6%-аар, түргэн хөрвөх чадварын харьцаа 0.04 дахинаас 0.10 дахин болж 120.1%-аар тус тус өссөн нь богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар сайжирсныг илэрхийлж байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ сөрөг хэвээр байгаа тул өр төлбөр/өөрийн хөрөнгийн харьцаа сөрөг утгатай хэвээр боловч -8.49-өөс -6.13 болж сайжирсан нь тайлант хугацаанд алдагдал буурч, өөрийн хөрөнгийн алдагдал багассантай холбоотой юм. Нийт өр төлбөрийн нийт хөрөнгөд эзлэх хувь 107% түвшинд тогтвортой хадгалагдсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны эцсээс 6.8%-аар буурсан хэдий ч эргэлтийн хөрөнгө 75.0%-аар өссөн нь хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн.
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>
	Борлуулалт 2026 оны эхний хагас жилийн байдлаар борлуулалтын орлого 84.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өссөн. Нийт борлуулалтын 86.1 хувийг дотоод, 13.9 хувийг гадаад зах зээл эзэлж байна. Дэлхийн хэмжээний маркетингийн томоохон кампанит ажлууд - Дэлхийн тавцанд Монгол өв соёлыг тунхаглаж буй “The HU” хамтлагтай хамтын ажиллагааг эхлүүлж, ГОВЬ брэндийн нүүр царай, дэлхийн хэмжээний элчээр хамтран ажиллахаар болов. - Олон улсын цахим спортын тавцанд өндөр амжилт үзүүлж буй “The MongolZ” багтай гадаад болон дотоод зах зээлд хамтын ажиллагааг эхлүүлж ГОВЬ брэндийн төлөөлөгчөөр ажиллаж эхлэв. Дотоод зах зээл - Тайлант хугацаанд дотоодын зах зээлд бүтээгдэхүүний үнийн бодлогыг шинэчилж, ижил төстэй загвартай бүтээгдэхүүн хоорондын үнийн ялгааг бууруулахад анхаарч ажилласнаар хэрэглэгчид сонголт хийхэд хялбар болов. - Мөн 2-р сараас дижитал маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлснээр дотоодын борлуулалтын өсөлтийг дэмжихэд гол үр дүнг үзүүлэв. - Дотоодын болон олон улсын хэрэглэгч нартаа тав тухтай, дэлхийн жишигт нийцсэн орчинд үйлчлэх зорилгоор дэлхийн хамгийн том (2,470м²) ноолуурын төрөлжсөн дэлгүүр болох "Galleria Store" салбарын 1-р давхрыг шинэчлэн засварлаж 4-р сарын 29-нд нээв. - ГОВЬ брэнд нь 2026 оноос эхлэн дэлхийн хэмжээний брэндүүд болон загварын олон талбарт нэрээ мөнхөлсөн алдарт дизайнер Naoki Takizawa-тай хамтарч ажиллахаар болсон. Улмаар 4-р сард FALL/WINTER 2026-27 EARLY ACCESS загварын шоуг зохион байгуулж Намар, өвөл худалдаанд гарах CashmereTech дэвшилтэт технологи бүхий шинэ загваруудыг танилцуулав. 6-р сард Говь ХК нь Монгол Улсын ТОП-100 ААН-ийн нэгээр дахин тодров. - Монгол Улсын Аварга О.Хангай ГОВЬ брэндийн албан ёсны төлөөлөгч болсон. Гадаад зах зээл - Гадаад зах зээлд борлуулалтын сувгаа өргөжүүлж 1-р сараас эхлэн Хятадын зах зээл дээр “RongMei” маркетинг агентлагтай хамтран ажиллаж эхлэв. - Мөн 2-р сараас Европын About You онлайн худалдааны платформоор бүтээгдэхүүнээ борлуулж эхлэв. 4-р сараас эхлэн вебийн систем шинэчлэл тогтмол хийгдсэнээр органик хайлт болон хиймэл оюун ухаантай хайлтууд дээр брэнд харагдалт ба шууд борлуулалт хийх боломжуудыг нэмэгдүүлсэн. 5 болон 6-р сараас БНСУ-ын цахим худалдааны зах зээлд стратегийн байр сууриа өргөжүүлэх зорилгоор тус улсын тэргүүлэх платформууд болох SSG.COM, LotteON болон 11st-д албан ёсоор нэвтэрч, борлуулалтаа эхлүүллээ. Эдгээр платформууд

нь олон тооны идэвхтэй хэрэглэгчид, борлуулалтыг дэмжих сурталчилгаа, урамшууллын системтэй тул олон сувгийн борлуулалтыг нэмэгдүүлэх чухал суурь болж байна.

Дизайн, бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- Говь ХК нь Креатив директор Naoki Takizawa-тай хамтран брэндийн үндсэн бүтээгдэхүүний шугам болох "Timeless Essentials" коллекцийг дэлхийн загварын чиг хандлага, орчин үеийн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шинэчилж, зах зээлд нэвтрүүлж байна. Шинэчлэгдсэн загварууд нь ноолуурын байгалийн зөөлөн шинж чанарыг хадгалсан хэвээр, хүний биеийн хөдөлгөөнийг дагасан эргономик эсгүүр, сайжруулсан суулт, өдөр тутмын тав тухыг хослуулснаараа онцлог бөгөөд хэрэглэгчдэд үе шаттайгаар хүрч байна.
- Тайлант хугацаанд олон улсын дизайнер брэндтэй хамтарсан анхны коллекц болох "GOBI CashmereTech by NAOKI TAKIZAWA" 2026 коллекцийг амжилттай танилцууллаа. Энэхүү коллекц нь дэлхийн тэргүүлэх технологийн үйлдвэрлэгчдийн өндөр үзүүлэлттэй үндсэн болон туслах материалыг ГОВЬ-ийн ноолууртай хослуулсан CashmereTech концепцийн бүтээгдэхүүнүүдээс бүрдэх бөгөөд ноолуурын хольцтой дүүргэлттэй гадуур хувцсаар дамжуулан тав тух, дулаан хадгалалт, хөнгөн жин, өндөр гүйцэтгэлийг нэгтгэсэн инновацид суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүний хөгжлийн эхлэлийг тавьж байна.

Үйлдвэрлэл

- Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх хүрээнд захиалгат ээрмэл утасны үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсгөв.
- Мөн технологийн процесс болон чанарын хяналтыг тасралтгүй сайжруулсны үр дүнд бэлэн бүтээгдэхүүний чанар 96.0% хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1% сайжирлаа.

Хүний нөөц

- 2026 оны эхний хагас жилд Говь ХК нь 1,303 орон тоотой ажиллахаар төлөвлөсөн бөгөөд 1,242 орон тооны гүйцэтгэлтэй ажилласан байна. Орон тооны дүүргэлтийг 95%, тогтворжилтыг 86%-тай хангаж ажиллалаа.
- Компанийн хэмжээнд нийт ажилтнуудад үнэлгээ хийж “Түлхүүр ажилтан” болон “Түлхүүр ажлын байр”-уудыг тодорхойлов.
- Ажилтнуудын идэвх оролцоог хангах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор ажилтнуудад чиглэсэн сургалт, идэвхжүүлэлтийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 297 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тогтвортой хөгжил

2026 оны эхний хагас жилд Говь ХК нь байгаль орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, тогтвортой үйлдвэрлэлийн чиглэлээр олон улсын стандартын хэрэгжилтийг бэхжүүлэх, нөөцийн үр ашиг, ажилтны аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр дараах онцлох ажлуудыг хэрэгжүүллээ.

- OEKO-TEX® бэлэн бүтээгдэхүүний гэрчилгээний хугацааг амжилттай сунгаж, бүтээгдэхүүний аюулгүй байдал, олон улсын баталгаажуулалтыг хийлгэв.
- ISO 50001 Эрчим хүчний менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, эрчим хүчний хэрэглээг оновчтой удирдах, үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлэв.
- Үйлдвэрлэлд ашиглагдаж буй 91 төрлийн химийн бодисын аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас (SDS)-ыг шинэчилж, химийн бодисын удирдлагыг олон улсын шаардлагад нийцүүлэн сайжрууллаа.
- Говь үйлдвэрийн цахилгааны ухаалаг тоолуурын системийг шинэчлэн онлайн хяналтын системд холбож, эрчим хүчний хэрэглээг бодит цагийн горимоор хянах, мэдээллийг төвлөрүүлэн удирдах боломжийг бүрдүүлэв.
- Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран байгаль орчны хяналтын байгууллагын 50 улсын байцаагчийг хамруулсан туршлага солилцох өдөрлөгийг зохион байгуулж, компанийн байгаль орчны менежмент, тогтвортой үйлдвэрлэлийн сайн туршлагыг

	танилцууллаа. 2026 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 1,137 ажилтан буюу нийт ажилтны 94.5 хувийг хамруулж, нийт 12,994 хүн/цагийн сургалтыг зохион байгуулан ажилтнуудын аюулгүй ажиллагааны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. - Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан баталгаажууллаа. Мөн үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэж, болзошгүй эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэв. - Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах өртөөчилсөн дадлага, сургалтыг зохион байгуулж, ажилтнуудын гамшгийн үеийн хариу арга хэмжээ авах чадавх, байгууллагын бэлэн байдлыг бэхжүүллээ.																						
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>																						
	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																						
4.	<i>Үнэт цаас гаргаагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>																						
	ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт, хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг. Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг. 2026 оны сонирхлын зөрчилтэй хэлцэл: ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 13-ны №09 тоот тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон. Эрсдэл, аудитын хорооны 1-р улирлын ээлжит хурал 2026 оны 04-р сарын 10-ны өдөр хуралдан 2026 оны 1-р улирлын сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй танилцаж хяналтыг хэрэгжүүлсэн. Харин хагас жилийн сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй 2026 оны 08-р сард хуралдах Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал дээр танилцахаар төлөвлөж байна. 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН МЭДЭЭЛЭЛ <table border="1"> <thead> <tr> <th>Огноо</th><th>Гэрээ хэлцлийн утга</th><th>Үнийн дүн</th><th>Гэрээний нөгөө тал</th><th>Гэрээний нөхцөл, болзол</th><th>Эхлэх огноо</th><th>Дуусах огноо</th><th>Хэлцэл баталсан ТУЗ-ийн тогтоол</th></tr> </thead> <tbody> <tr> <td>2026.02.13</td><td>2026 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд</td><td>-</td><td>Таван Богд Группийн охин компаниуд</td><td>Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг</td><td>2026.01.01</td><td>2026.12.31</td><td>№09</td></tr> </tbody> </table>							Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан ТУЗ-ийн тогтоол	2026.02.13	2026 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд	-	Таван Богд Группийн охин компаниуд	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг	2026.01.01	2026.12.31	№09
Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан ТУЗ-ийн тогтоол																
2026.02.13	2026 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд	-	Таван Богд Группийн охин компаниуд	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг	2026.01.01	2026.12.31	№09																

	зөвшөөрөл олгох			зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулах			
2026.05.06	ХААН Банкны Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, Ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих ногоон зээлийн гэрээ байгуулах тухай	30 тэрбум төгрөг	ХААН Банк	"Ноолуурын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих ногоон зээл"-ийн гэрээ байгуулах	2026.05.14	2028.05.14	№16
2026.06.17	Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай	-	Таван Богд Холдингс ХХК	Таван Богд Холдингс ХХК-ийн ЕСБХБ-тай байгуулах гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Говь ХК-ийн ЕСБХБ-тай 2025.05.30-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулсан хөрөнгүүдийг барьцаалах	2026.06	2031.06	№21

ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ


(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2025.06.30	2026.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	128,597,177	176,444,000
Холбоотой талаас авсан санхүүжилт	162,927,177	167,444,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	570,250	497,538
Холбоотой талаас авсан худалдан авалт	879,791	3,330,151
Хүүгийн орлого	-	1,651,822
Хүүгийн зардал	2,658,767	1,269,983
Түрээсийн орлого	297,952	298,621
Түрээсийн зардал	701,025	761,300

Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно. Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 13-ны №09 тоот тогтоолоор олгосон.

5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Таван Богд Холдингс ХХК

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

26,234

/2026.06.30-ны байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2025.12.31		2026.06.30	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	682,106,188	87.44%	682,106,188	87.44%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон хувь эзэмшилд өөрчлөлт ороогүй.

2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 29-ний өдрийн 14:00 цагт ГОВЬ ХК (Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхим)-д 89.41% ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 15,246,483 ширхэг хувьцааны 1.95 хувийн саналын эрхтэй 488 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 682,252,889 ширхэг хувьцааны 87.46 хувийн саналын эрхтэй 50 хувьцаа эзэмшигч буюу нийт 697,499,372 ширхэг хувьцааны саналын эрхтэй 538 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.41% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

- Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол;
- ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан.

Хэлэлцэн баталсан асуудал

- ТУЗ-өөс компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлт;
- ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсөв.

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

- Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг 99.99%-ийн саналаар батлав.
- ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2026 оны 05-р сарын 04-ний өдөр ХЭХ-ын тайлан (Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой 30 хуудас бүхий хэвлэмэл материал 1 ширхэг, Хурлын тайлан болох 84 хуудас хэвлэмэл материал 1 багц, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

ТУЗ-ийн хараат бус гишүүд



Д.ГЭРЭЛМАА

Нэр дэвшүүлэх хорооны дарга,
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



Д.ХҮРЭЛБААТАР

Цалин урамшууллын хорооны дарга,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Р.САРАНЦЭЦЭГ

Эрсдэл, аудитын хорооны дарга,
Цалин урамшууллын хорооны гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүд



ТУЗ-ийн дарга

Таван Богд Групп,
Ерөнхийлөгч



Д.ХУЛАН

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Таван Богд Групп,
ТУЗ-ийн дарга



Б.АМАРСАЙХАН

Говь ХК,
Гүйцэтгэх захирал



Ц.ОРГИЛБОЛД

Говь Кашмер Европ ХХК,
Гүйцэтгэх захирал



Б.ОРГИЛ

Цалин, урамшууллын хорооны гишүүн

Таван Богд Холдингс ХХК,
Санхүү удирдлага хариуцсан захирал



Б.ЦЭЭНЯМ

Эрсдэл, аудитын хорооны гишүүн

Ар И Ди Эженси ХХК,
Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөнтэй холбогдуулан 2026 оны 05-р сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн [шийдвэрээр](#) түүнийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, 2027 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох хүртэлх хугацаагаар Р.Саранцэцэгийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсон.

МЕНЕЖМЕНТ БАГИЙН ЗАХИРЛУУД



Гүйцэтгэх
захирал
Б.АМАРСАЙХАН



Дизайн,
үйлдвэрлэл
хариуцсан
дэд захирал
Б.БОЛОРМАА



Дизайн
хөгжүүлэлт
хариуцсан
захирал
А.УЧРАЛ



Гадаад
борлуулалт
хариуцсан
захирал
Г.АНУДАРЬ



Дотоод
борлуулалт
хариуцсан
захирал
Л.САРАН



Санхүү бүртгэл
хариуцсан
захирал
Д.СОДГЭРЭЛ



Хүний нөөц
хариуцсан
захирал
Т.ИЧИНХОРЛОО



Үйл ажиллагаа
хариуцсан
захирал
Э.ЗОЛЗАЯА

7. Үнэт цаас гаргаагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	2	1	8	24	26	-	5	21
Эрсдэл, аудитын хорооны хурал	2	-	-	13	5	4	4	-
Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	-	1	7	5	4	3	1
Цалин урамшууллын хорооны хурал	1	-	-	6	7	-	1	-
Нийт	6	1	9	50	43	8	13	22

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 ээлжит хурал, 1 ээлжит бус хурал, 9 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллав.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 50 асуудлыг хэлэлцэн, 43 шийдвэр гаргаж, 22 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 21 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 13, санхүүжилттэй холбоотой 6, хүний нөөцтэй холбоотой 2)
- Нэр дэвшүүлэх хорооноос 1 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 8 санал зөвлөмж, 13 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 13-ны өдрийн [№03 тоот](#) тогтоолын дагуу компанийн 2025 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2025 оны Жилийн үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2025 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2026 оны 1-р улирал болон эхний хагас жилийн санхүүгийн тайлан;
- 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
- 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал;
- 2025 оны жилийн эцсийн байдлаарх Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан;
- Тухай бүр хүргэх мэдээллүүд.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

2026 оны эхний хагас жилийн байдлаар ТУЗ-өөс дараах бодлого, журмыг шинэчлэн [баталсан](#). Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам
- Олон нийтэд хүргэх мэдээллийн журам

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн үнэлгээний аргачлалын дагуу Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар компани өөрийгөө үнэлж, Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан үр дүн 2026 оны 04-р сард гарсан. Тус үнэлгээгээр Говь ХК-ийн компанийн засаглалын кодексийн хэрэгжилт өмнөх үнэлгээнээс өөрчлөлтгүй буюу **98.6% засаглал хэвийн, эрсдэлгүй** гэж [үнэлэгдсэн](#).

2026 оны хагас жилийн үнэлгээг хийж Санхүүгийн зохицуулах хороо руу илгээсэн бөгөөд баталгаажуулалтын үр дүнг хүлээж байна.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: “Говь” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2026 оны 07-р сарын 23-ны өдөр

